



ШУВУУН ХАР УУЛ ХХК

ЗАВХАН АЙМГИЙН ЗАВХАНМАНДАЛ СУМЫН НУТАГТ ОРШИХ БАЯНХАЙРХАН ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР MV-021001
АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР 5320607**

ХЯНАСАН:

БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн
удирдлагын газрын Ахлах Мэргэжилтэн

Ц.Жаргалнэмэх

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

Шувуун хар уул ХХК-ийн Гүйцэтгэх Захирал

Г.Золбаяр

Шувуун хар уул ХХК-ийн БО мэргэжилтэн

Б.Алтангэрэл

АГУУЛГА

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Компанийн товч танилцуулга

Техник эдийн засгийн үнэлгээ

Байгаль орчны үнэлгээ

ОРДЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ГОЛ ЗОРИЛТ

1. Тухайн оны уулын ажлын гүйцэтгэлийн товч танилцуулга
2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт
4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт
9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт
10. Аймаг, нийслэлийн Засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ
11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт
12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Манай компани 2009 оноос уул уурхайн салбарт 100 хувь дотоодын хөрөнгө оруулалтаар үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд Завхан аймгийн Завханмандал суманд орших Баянхайрхан талбайд MV-021001 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг АМГТГ-ын кадастрын албанаас 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдөр авсан болно. Гравитацийн аргаар алтны хүдэр боловсруулах үйлдвэрийг байгуулан 2021 оны 9 дүгээр сараас ажиллаж эхэлсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Улсын комиссын 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 20/24 тоот актаар байнгын ашиглалтад хүлээн авсан.

Гравитацийн аргаар алтны хүдэр боловсруулах үйлдвэрийг байгуулан 2021 оны 9 дүгээр сараас ажиллуулж эхэлсэн. Уусган баяжуулах үйлдвэрийг барьж, барилга байгууламжийг нь Улсын комисст хүлээлгэн өгсөн.

ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ

Төслийн олборлолтын техник эдийн засгийн үндэслэлийг 2018 онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан. 2021 онд нэмэлт тодотгол хийлгэсэн.

	ТЭЗҮ	Огноо	Гүйцэтгэсэн байгууллага
1	Завхан аймгийн Завханмандал сумын нутагт орших Баянхайрхан талбайн Зүүн шувуу уулын алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл	2018.07.10	“Пауэр Опен Пит” ХХК
2	Завхан аймгийн Завханмандал сумын нутагт орших Баянхайрхан талбайн Зүүн шувуу уулын алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл тодотгол	2021.07.06	GLOGEX Geology & Mining Consulting

БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ

Төслийн үйл ажиллагааны явцад гарах байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 2018 оны 12 сард зөвлөх үйлчилгээний мэргэжлийн байгууллага болох Хос санаа ХХК-иар хийлгэж, БОАЖЯ-ны БОНБУ-ний мэргэжлийн зөвлөлийн хуралд хэлэлцүүлэн батлуулсан. 2021 онд нэмэлт тодотголыг Эм И Си Эс Зэт Би ХХК-иар нэмэлт тодотгол хийлгэсэн.

	Ерөнхий үнэлгээ	Огноо	Гүйцэтгэсэн байгуулга
1	Баянхайрхан нэртэй алтны үндсэн ордыг ашиглах төсөл	2017.11.14	БОАЖЯ
2	Алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах, баяжуулах үйлдвэрийн төсөл	2021.08.11	БОАЖЯ
	Нарийвчилсан үнэлгээ		
1	Завхан аймгийн Завханмандал сумын нутаг “Баянхайрхан талбайн Зүүн шувуу уулын алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах” төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ	2018 оны 12 сар	“Хос санаа”ХХК

2	Завхан аймгийн Завханмандал сумын нутагт байрлах “Шувуун хар уул” ХХК –ийн MV-021001 дугаартай Зүүн шувуун уулын алтны бүлэг ордын зүүн болон өмнөд хэсгийн алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайлан	2021 оны 12 сар	“ЭМ И СИ ЭС ЗЭТ БИ” ХХК
Байгаль орчны аудит			
1	“Шувуун хар уул” ХХК-ийн Завхан аймгийн Завханмандал сумын нутагт орших Баянхайрхан (MV-021001) алтны үндсэн ордыг далд аргаар олборлон баяжуулах төсөлд хийсэн байгаль орчны төлөвлөгөөт аудитын тайлан	2021 оны 11 сар	“Алтан шанага” ХХК
2	Шувуун уулын алтны бүлэг ордын зүүн болон өмнөд хэсгийн алтны үндсэн ордыг далд аргаар ашиглах төслийн байгаль орчны аудитын тайлан	2023 оны 8 сар	Эко-Акюрэси ХХК

Ордын товч танилцуулга

Ордын нөөц

Алтны орд газрын нөөц баялгийг 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр Монгол Улсын эрдэнэсийн санд бүртгэхийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд санал оруулж батлуулсан. 2021 оны 03 дугаар сарын 16-ны өдөр Н/32 тушаалаар нөөц дахин Монгол Улсын эрдэнэсийн санд бүртгэхийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд санал оруулж батлуулсан.

Зүүн хэсгийн алтны үндсэн ордод алтны захын агуулга 0.1 г/т түвшин 21378.82 тн хүдэр, 100.38 кг алт үүнээс бодитой (В) нөөц 14761.17 тн хүдэр 73,67 кг алт, боломжтой (С) нөөц 6617.65 тн хүдэр, 26.71 кг алт байна.

Өмнөд хэсгийн алтны үндсэн ордод бодитой В нөөц 131,854.5тн хүдэр, 989.61кг алт, боломжит С нөөц 76,90,25 тн хүдэр 316,09 кг алт байна.

Нийт бодит болон боломжит В-С зэргээр 230,2 мян.тн хүдэрт 1406.1 кг алтны нөөцтэй ба үйлдвэрлэлийн аргаар 219,1 мян.тн хүдрийг олборлон боловсруулж 1159.4 алтыг гарган авахаар төлөвлөсөн байна.

Далд уурхай

Уурхайн олборлолт далд хэлбэрээр явагдах бөгөөд, Өмнөд хэсгийн далд уурхайг налуу амаар олборлоно. Одоогоор Өмнөд хэсгийн далд уурхайн олборлолтын ажлыг тогтмол явуулж баяжуулах үйлдвэрийг хүдрээр ханган ажиллаж байна. Өмнөд шувуу уулын далд уурхай нь 6 жилийн турш ажиллахаар төлөвлөгдсөн. Далд уурхайн ашиглалтын системийн сонголтыг хүдрийн биетийн уул-геологийн нөхцөлд тулгуурлан сонгосон бөгөөд Зүүн шувуу уулын далд уурхайг хүдэр хоршоолох ашиглалтын системээр, Өмнөд шувуу уулын далд уурхайг баганат ашиглалтын системээр олборлохоор тус тус сонгосон.

Далд уурхайн хүчин чадлыг баяжуулах үйлдвэрийн хүчин чадалд тулгуурлан хоногт 150 тн хүдэр олборлоно.

Баяжуулах үйлдвэр

Баяжуулах үйлдвэр гравитаци-уусгалтын хосолсон аргыг ашиглахаар төлөвлөсөн ба үйлдвэрийн гравитацийн хэсэг болох хүдэр бутлах, нунтаглах, гравитаци, тоног төхөөрөмжийг 2019 онд ашиглалтад оруулан хүдэр баяжуулан боловсруулж байна. Уусган баяжуулах хэсэг болох уусгалтын тоног төхөөрөмж, десорбци, хайлуулалт, хатаах компрессор зэргийг 2024 онд ашиглалтад оруулах бөгөөд технологийн туршилтаар гравитаци-уусгалтын технологийн аргаар алтны металл авалт нийт 96.75% хүрнэ.

Баяжуулах үйлдвэрийн үндсэн үзүүлэлт

Хүдэр баяжуулах үйлдвэрийн хүчин чадал	45,000 тн/жил
Хүдэр баяжуулах үйлдвэрийн ажиллах хугацаа	6 жил
Нунтаглах, баяжуулах үйлдвэрийн цаг ашиглалт	365 хоног/жил
Хүдэр бэлтгэх технологи	87.0%
Нунтаглагдсан хүдрийн ширхэглэл	2 шатны бутлалт, 1 шатны нунтаглалт
Хүдэр баяжуулах технологи	0.074 мм
Хаягдлын хэлбэр	Гравитаци-уусгалт хосолсон Хуурай

Төслийн байршил

Орд нь Завхан аймгийн Завханмандал сумын нутагт орших бөгөөд Завханмандал сумын төвөөс 58 км, Завхан аймгийн төвөөс баруун тийш 210 км, Улаанбаатар хотоос баруун тийш 1200 км зайд орших бөгөөд Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт орших Баян-Айргийн алт, зэсийн ордоос зүүн хойш 55 км зайд байрладаг.



Төслийн талбайн байршил

Тусгай зөвшөөрлийн талбайн мэдээлэл

Тусгай зөвшөөрлийн талбайн нэр, дугаар	Талбайн хэмжээ (га)	Солбицлууд	
		х	у

Баянхайрхан MV-021001	1460,51	94° 40' 41,3"	48° 14' 49.5"
		94° 40' 41,3"	48° 12' 46.66"
		94° 39' 19.75"	48° 12' 46.66"
		94° 39' 19.75"	48° 12' 20.87"
		94° 38' 22.75"	48° 12' 20.87"
		94° 38' 22.75"	48° 13' 25.3"
		94° 37' 30.1"	48° 13' 25.3"
		94° 37' 30.1"	48° 14' 49.5"



Төслийн талбайн бодит зураглал

2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Тайлант онд байгаль орчны мониторингийн ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай хэмжилтийн багаж хэрэгслээр хангах, тэдгээрийг ашиглан хэрхэн хэмжилт хийх, мэдээллийн сан бүрдүүлэх замаар байгаль орчны ажилтнуудыг чадавхжуулах ажлуудыг гол зорилтоо болгон ажиллалаа.

Уг зорилтын хүрээнд чөлөөт уналтын аргаар тоосны хэмжилт хийх багаж, агаар дахь O₂, CO₂, SO₂ болон PM_{2.5}, PM₁₀ тоосонцор, дэгдэмхий органик нэгдэл хэмжих зөөврийн багаж, гүний

усны түвшин хэмжигч багаж худалдан авч хяналт мониторингийн ажлыг гүйцэтгэх боломжтой болсон.

Түүнчлэн энэ жил шинээр 2 байгаль орчны ажилтан авч ажиллуулж эхэлсэн бөгөөд ажилчдаа чадавхжуулах зорилгоор “Эрсдэлтэй ажлын байрны сургалт”, “Ургамалжилтын мониторинг”, “Хариуцлагатай уул уурхай” баруун бүсийн чуулга уулзалт, “Уул уурхайн нөхөн сэргээлт, орчны хяналт шинжилгээ” зэрэг сургалтуудад хамруулж ажиллалаа.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн Байгаль орчин аялал жуулчлалын сайдын А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам-2019”-ийг үндэслэн боловсруулж, журамд тусгагдсанаар энэ жилийн БОМТ-нд тусгагдсан 70.582.000 /Далан сая таван зуун наян хоёр мянга/ төгрөгийн 50% болох 35.291.000 /Гучин таван сая хоёр зуун ерэн нэгэн мянга/ төгрөгийг байгаль орчны төрийн захиргааны төв байгууллагын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансанд байршуулсан болно.

Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд Баянхайрхан төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Байгаль орчин: Алтны үндсэн ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас 42 сөрөг нөлөөллийг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрд үзүүлэхээр байна. Үүний 3 буюу 7.1% нь “бага”, 19 буюу 45.2% нь “дунд”, 18 буюу 42.8% нь “их”, 2 буюу 4.8% нь “маш их” гэсэн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамаарагдаж байна. Эндээс үзэхэд төслийн зүгээс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн хэмжээ дундаас их хэмжээнд байхаар байна. Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийн хэмжээ агаарын чанарт 16%, газрын гадарга, хэвлийд 19%, хөрсөн бүрхэвчид 17%, газрын доорх усанд 14%, ургамлан нөмрөгт 17%, амьтны аймагт 17% гэсэн үзүүлэлт гарч байгаа ба газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл илүү байна.

Хүний эрүүл мэнд: Алтны үндсэн ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас уурхайн ажилчид, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх нийт 31 нөлөөллийг тооцов. Тэдгээр нөлөөллүүдийн 14 буюу 45% нь бага, 17 буюу 55% нь дунд зэргийн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамрагдаж байна.

Нийгэм эдийн засаг: Алтны үндсэн ордыг ашиглах төслөөс төсөл хэрэгжих Завхан аймгийн Завханмандал сумын нийгэм эдийн засагт ажлын байр нэмэгдэх, орон нутгийн худалдан авалт сайжрах зэргээр ихэвчлэн эерэг нөлөөлөл үзүүлэх нь боломжтой байна.

1. ТУХАЙН ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Далд уурхайн олборлолт

Тайлант онд уулын ажлыг Өмнөд болон Зүүн хэсэгт явуулахаар төлөвлөж байсан боловч ордын Өмнөд хэсэгт далд уурхайн олборлолтын ажил явагдсан. Зүүн хэсгийн хүдрийн биет дээр далд уурхайн малталт нэвтрэлт, олборлолтын ажил хийгдээгүй байна.

Малталт нэвтрэлт, ашиглалтын түвшин

Малгалт нэвтрэлт	Хэмжих нэгж	Утга
Ашиглалтын 3-р түвшний малгалт		
Налуу ам	м	-
Холбоос малгалт	м	50
Тээврийн штрэк	м	100
Орм малгалт	м	90
Бусад	м	30
Нийлбэр		270
Ашиглалтын 4-р түвшний малгалт		
Налуу ам	м	72
Холбоос малгалт	м	50
Тээврийн штрэк	м	205
Орм малгалт	м	110
Бусад	м	30
Нийлбэр		467
Нийлбэр		737

Далд уурхайн олборлолт, хоосон чулуулга гаргалт

Тус онд одоогийн байдлаар хоногт дунджаар үйлдвэрлэлийн 110 тн хүдэр уурхайгаас олборлож байна. 2024 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар нийт 16.9 мян.м³ чулуулаг уурхайн хоосон чулуулгийн овоолгод хураагдсан. Нийт хоосон чулуулгийн овоолгын эзлэх талбайн хэмжээ 1.5 га байна. Доор зурагт 2024 оны 4 сарын байдлаар уурхайн хоосон чулуулгийн овоолгын зургийг үзүүлээ.

Хоосон чулуулгийн овоолго тайланд онд тэлээгүй буюу эвдрэлд шинээр газар өртөөгүй болно.



2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тайлант онд сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр нийт 21 ажил төлөвлөсөн. Гүйцэтгэсэн ажлын тайланг дараах хүснэгтэд харууллаа.

№	Төлөвлөгөөнд Тусгагдсан ажлууд	Хамрах хүрээ	Биелэлт
---	-----------------------------------	--------------	---------

2.1 Агаарын чанар

1	Бутлуураас үүсэх тоосны тархалтыг тоосны чөлөөт уналтын аргаар хэмжилт хийж, судлах	Уурхайн хэмжээнд	Тоосжилтын гол эх үүсвэр болох Боловсруулах үйлдвэрийн Бутлуурын хэсгээс үүсэх тоосны тархалтыг тогтоох зорилгоор 5 дугаар сард тоосны чөлөөт уналтын аргаар хэмжилт хийсэн. Дүнг доорх зургаас харна уу.
2	Хаягдлын сангийн агаар дахь синилийн хүчлийн агууламжийг хэмжиж, бүртгэл хөтлөх	Хаягдлын сангийн орчим	Энэ оны 10 дугаар сарын байдлаар манай уурхай химийн бодис хэрэглэж эхлээгүй байна. Үүнтэй холбоотойгоор дараах хэмжилт хийгдээгүй болно.
3	Тээврийн хэрэгслүүдээс ялгарах хийг хянах, машин техникийн засвар үйлчилгээг төлөвлөсөн хугацаанд тогтмол хийх	Бүх тээврийн хэрэгсэл	Уурхайд явж буй машин механизмын засвар үйлчилгээг тогтмол хийж байна. Харин тээврийн хэрэгслүүдээс ялгарах хийнүүдийн үзлэг шалгалтыг ирэх 10 дугаар сард аймгийн Авто тээврийн газраар хийлгүүлэх болно.
4	Завхан аймгийн УЦУОШГ-тай гэрээ байгуулан, цаг агаарын мэдээ хүлээн авч, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглах	Уурхайн хэмжээнд	Завхан аймгийн УЦУОШГ-тай гэрээ байгуулан, цаг агаарын мэдээг долоо хоногт 2 удаа хүлээн авч, үйл ажиллагаандаа ашиглаж байна.
5	Ажилчдын ээлжийн амралтын тээвэрлэлтийг хийх маршрутыг тогтоон ашиглах	Орон нутгийн зам	Ажилчдын ээлжийн амралтын тээвэрлэлтийг хийх маршрутыг 2024 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 24/10 тоот тушаалаар батлан, мөрдөн ажиллаж байна. Маршрутыг доор хавсаргав.
6	Тээврийн хэрэгсэл технологийн замаар 40км/цаг хурдтай явж байгаа эсэхэд хяналт тавих	Технологийн зам	Уурхайн талбайд хөдөлгөөнт техник ашиглах журамд уурхайн дотоод тээврийн замд 20 км/цаг, УБҮ болон уурхай хоорондын тээврийн замд хурдны дээд хязгаар 40 км/цаг байхаар тогтоосон. ХАБЭА-н хэлтсийн ажилтнууд байнгын хяналт тавьж ажиллаж байна.

2.2 Газрын гадарга болон газрын хэвлий

1	Далд уурхайгаас баяжуулах үйлдвэр хүртэлх технологийн замыг ашиглах, шинээр зам гаргахгүй байх	Технологийн зам	Далд уурхайгаас баяжуулах үйлдвэр хүртэл технологийн нэг замыг ашиглаж байна. 7 хоног бүрийн үзлэг шалгалтаар шинээр зам гаргасан эсэхэд хяналт тавьж байна.
2	Шинээр газар хөндөгдсөн тохиолдолд стандартыг баримтлан ажиллах	Уурхайн хэмжээнд	Одоогийн байдлаар уурхайд шинээр газар хөндөлт хийгдээгүй байна.
3	Долоо хоног бүрийн байгаль орчны үзлэг шалгалтыг хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах	Уурхайн хэмжээнд	7 хоногийн пүрэв гариг бүрд уурхайн хэмжээнд ажлын байрны үзлэг шалгалтыг хийж байна.
4	Станц дээр асгаралтын иж бүрдэл байрлуулж, ашиглах сургалт явуулах	Жолооч нарт	Асгаралтын иж бүрдлийг ШТС-ын зүүн талд байрлуулсан.

2.3 Газрын доорх ус

1	Шатах тослох материалаар бохирдсон хөрсийг хадгалах талбайг авто засварын газрын дэргэд шинээр байгуулах	Уурхайн хэмжээнд	<p>Бохирдсон хөрс хадгалах талбайг уурхайн ШТС-ын галын сарайны дэргэд байгуулсан.</p> 
2	Хаягдлын сангийн дэргэд хяналтын 2 цооног гаргах	Үйлдвэрийн талбай	Боловсруулах үйлдвэрийн хаягдлын сангийн дэргэд гүний усны хяналтын 2 цооногийг шинээр гарган тоногдосон.
3	АШЦБ-ын технологийн горимыг сайжруулах	АШЦБ	АШЦБ-ын технологийн горимыг сайжруулах талаар судалгаа хийж байна.
4	Худгийн тоолуур, ус хангамжийн шугам хоолойд Завханмандал сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Байгаль хамгаалагч нартай хамтран хяналт тавьж ажиллах	Уурхайн хэмжээнд	Уурхайн ус ашиглалтын байдалд сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Байгаль хамгаалагч нар сар бүр хяналт тавьж, ажиллаж байна. Сар бүрийн тоолуур баталгаажуулалтын хуудсыг хавсаргав.
5	Ус ашиглалтын дүгнэлтийг Усны газраас авах		Усны газраас 2024 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 01/369 тоот албан бичгээр ус ашиглуулах дүгнэлтийг ирүүлсэн. Дүгнэлтийг хавсаргав.
6	ХНЗГСГЗ-наас ус ашиглах зөвшөөрөл авч гэрээ байгуулах		ХНЗГСГЗ-ны даргын 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн А/12 дугаар тушаалаар манай уурхайн ус ашиглах зөвшөөрөл олгож, гэрээ байгуулсан. Зөвшөөрөл болон гэрээг хавсаргав.
7	Ус бохирдуулсны дүгнэлт гаргуулах		Ус бохирдуулсны дүгнэлтийг улирал бүр холбогдох бичиг баримт болон шинжилгээний хариуг Усны газарт тогтоосонд хугацаанд өгч гаргуулж байна.
8	Хаягдлын сангийн дэргэдэх нурсан хяналтын цооногийг орон нутгийн байгууллагад хүлээлгэн өгөх		2022 онд Хаягдлын сангийн хойд талд гүний усны хяналт хийх зорилгоор цооног өрөмдсөн боловч тухайн цооног хуурай байгаа тул усны тухай хуулийн 22.17 дахь зүйлд заасны дагуу битүүмжлэн Завханмандал сумын ЗДТГ-т хүлээлгэн өгөхөөр албан хүсэлт хүргүүлээд байна. / Албан хүсэлтийг хавсаргав./
2.4 Ургамлан нөмрөг			
1	Газар хөндөх тохиолдолд урьдчилан газар хөндөхийн өмнө үзлэг шалгалтыг хийж, газар хөндөлтийг аль болох бага түвшинд байлгах	Уурхайн хэмжээнд	Одоогийн байдлаар уурхайд шинээр газар хөндөлт хийгдээгүй байна.
2.5 Амьтны аймаг			


1	Уурхайн нийт ажилтнуудын дунд тухайн бүс нутгийн амьтад болон тэдгээрийг авран хамгаалах талаар сургалт орох	Уурхайн хэмжээнд	Амьтны мэргэжлийн байгууллага болох “Отгон бор хавцал” ТББ-аас хийж гүйцэтгэсэн ажилтай холбоотой тайлан, мэдээлэл, сургалт өгөх зорилгоор уулзалт зохион байгуулсан Энэ сургалтад БООНХхэлтсийн ажилтнууд болон холбогдох мэргэжилтнүүд хамрагдсан. / Танхим болон онлайнгаар
2	Мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж, биологийн олон янз байдлын судалгаа хийлгэх	Уурхайн хэмжээнд	“Отгон бор хавцал” ТББ-тай 2024 оны 6 дугаар сарын 27-ны өдөр 24/12 тоот, Биологийн олон янз байдлын судалгаа хийлгэх тухай гэрээг байгуулсан. Тухайн байгууллага гэрээний дагуу 7 дугаар сарын 24-нээс 27-ны хооронд уурхайн талбайд ирж, амьтны зүйлийн бүрдлийг тогтоож хөдөлгөөн мэдрэгчтэй камеруудыг 2 сарын хугацаанд байршуулан судалгааг хийж гүйцэтгэсэн болно.

2.1 Агаарын чанар


Тоосжилтын гол эх үүсвэр болох Боловсруулах үйлдвэрийн Бутлуурын хэсгээс үүсэх тоосны тархалтыг тогтоох зорилгоор 5 дугаар сард тоосны чөлөөт уналтын аргаар хэмжилт хийсэн. Судалгаагаар бутлуураас 100 метрийн зайд тоосжилтын хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс ир гарч байсан ч 200 метрийн зайд буурч улмаар 1000 метрийн зайд маш бага хэмжээнд хүрсэн нь харагдаж байна.



Бутлуураас үүсэх тоосны тархалтын хэмжилт хийх цэгүүд



Боловсруулах үйлдвэрийн бутлуурын хэсгээс үүсч буй тоосны тархалтын дүн



Ээлж солилцох аяллын батлагдсан маршрут

2.2 Газрын гадарга болон газрын хэвлий

Уурхайн технологийн замыг хавар намрын тоосжилттой үед хуваарийн дагуу усалж, тээврийн хэрэгслүүдийн хурдны хязгаарт тогтмол хяналт тавин ажиллаж байна.



Уурхайн технологийн зам

2.3 Газрын доорх ус



Шинээр байгуулсан бохирдсон хөрс хадгалах талбай

2.5 Амьтны аймаг

“Отгон бор хавцал” ТББ-тай 2024 оны 6 дугаар сарын 27-ны өдөр 24/12 тоот, Биологийн олон янз байдлын судалгаа хийлгэх тухай гэрээг байгуулсан. Тухайн байгууллага гэрээний дагуу 7 дугаар сарын 24-нээс 27-ны хооронд уурхайн талбайд ирж, амьтны зүйлийн бүрдлийг тогтоох эхний шатны судалгааг хийж хөдөлгөөн мэдрэгчтэй камеруудыг байршуулан гүйцэтгэсэн болно.



Зэрлэг амьтны судалгаанд зориулан хөдөлгөөн мэдрэгч камер байрлуулж буй байдал

Уурхайн нөлөөллийн бүсэд бүртгэгдсэн ан амьтад							
№	Амьтны нэр төрөл	Латин нэр	Шинээр бүртгэгдсэн	Бүртгэлтэй эсэх	Давтамж	Он сар	Байршил
1	Хонин гүрвэл			+	2	2024.06.15	Худаг
2	Туулай	<i>LEPUS TOLAI PALLAS,</i>		+	байнга		Хүлэмж, уурхайн талбай
3	Оготно			+	байнга	2024.05.15	Уурхайн талбайд
4	Зурам	<i>Spermophilus erythrognus</i>		+	байнга	2024.05.17	Уурхайн талбайд
5	Үнэг	<i>VULPES LINNAEUS</i>		+	Байнга		Баяжуулах үйлдвэрт
6	Бамбай хоншоорт могой	<i>Gloydus Halys</i>		+	5	2024.05.26	Баяжуулах үйлдвэрт
7	Могой гүрвэл			+	байнга	2024.06.25	Хүлэмж
8	Хадны тагтаа	<i>Columba rupestris</i>		+	байнга	2024.06.27	Зүүн ам
9	Цагаан зээр	<i>Procapra gutturosa</i>		+	байнга	2024.07.13	Уурхайн талбайд
10	хярс	<i>VULPES CORSAC, LINNAEUS</i>		+	байнга	2024.07.16	
11	Үхэр оготно			+	байнга	2024.07.26	
12	Үлийн цагаан оготно			+	байнга	2024.07.28	
13	Алаг даага			+	байнга	2024.08.10	
14	Өмхий хүрэн			+	байнга	2024.08.20	

15	Цагаан зээр	<i>Procapra gutturosa</i>		+		2024.08.04	Төслийн талбайн ойролцоо
16	Үнэг	<i>VULPES, LINNAEUS</i>		+	байнга	2024.10.04	Өмнөдийн ам
17	Туулай	<i>LEPUS TOLAI PALLAS</i>		+	байнга	2024.10.17	Зүүн ам
18	Чоно	<i>Canis lupus</i>		+	байнга	2024.09.05	Өмнөд ам
19	Хярс	<i>VULPES corsac</i>		+	байнга	2024.10.02	Өмнөд ам



Өмнөд ам бүртгэгдсэн чоно



Хүлэмж ойролцоо бүртгэгдсэн гүрвэл



Үйлдвэрийн ойролцоо тааралдсан могой



Кемтийн ойролцоо тааралдсан могой

3.НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн нөхөн сэргээлтийг цөлөрхөг хээрийн бүс нутагт дасан зохицсон бэлчээрийн олон наст ургамлын зүйлийн бүрдлийг нэмэгдүүлэх замаар байгалийн унаган төрхөд ойртуулан, цаашид бие дааж ургах нөхцөлийг бүрдүүлэн техникийн нөхөн сэргээлтийг 3 га талбайд, биологийн нөхөн сэргээлтийг 1 га талбайд хийж гүйцэтгэв.

2.1 ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

“Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS5917:2008” стандартын шаардлагыг баримтлан Боловсруулах үйлдвэрээс Өмнөд ам явах зам дагуу эвдрэлд өртсөн 3 га талбайг ковш болон экскаватороор тэгшлэн хэлбэржүүлж техникийн нөхөн сэргээлт хийсэн.



Үйлдвэрээс өмнөд ам хүрэх зам дагуу техникийн нөхөн сэргээлт /нөхөн сэргээлт хийхээс өмнө/



Техникийн нөхөн сэргээлтийн ажлын явц

2.2 БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

Зүүн амны нөхөн сэргээлт Уурхайн Зүүн амны өмнө талд 1 га талбайд MNS5918:2023 “Эвдэрсэн газрыг ургамалжуулах” техникийн шаардлага стандартын шаардлагыг баримтлан биологийн нөхөн сэргээлтийг хийлээ.

Цаашид тухайн газар бэлчээрийн зориулалтаар ашиглагдах тул үрийн сонголтыг тухайн бүс нутгийн экосистемд дасан зохицсон, малд идэнгэ сайтай бэлчээрийн олон наст дараах ургамлууд болох ерхөг, хошоон, царгасыг сонгон тариалсан.



Нөхөн сэргээлт хийж байгаа нь



Ургалтын байдал /8-р сар/

Үрийн 1 га-д 55 кг байхаар тооцон цацаж, нэмэлтээр хөрс сайжруулах арга хэмжээг авсан. Хөрсний үржил шимийг сайжруулах зорилгоор биоалзмагийг 1 га-д 40 кг, уурхайн ойролцоох малчин өрхүүдээс бууц авч, 1 га-д 18 тн байхаар тооцоолж хөрс сайжруулалтыг хийсэн.

Тарилт хийсэн талбайд 2024 оны 5 дугаар сарын сүүлийн 7 хоногоос 9 дүгээр сарын эхэн хүртэл хуваарийн дагуу өнжөөд 1 удаа усалгааг хийсэн.

Уурхайн байрлаж буй бүс нутаг нь цөлөрхөг хээрийн бүсэд хамаардаг бөгөөд хэвийн бэлчээрийн ургамлын бүрхэц 25-32.5% байдаг талаар 2018 онд гаргасан Завхан аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дурдсан байсан.

Энэ оны 8 дугаар сард гүйцэтгэсэн ургамлын мониторингийн судалгаагаар нөхөн сэргээлтийн талбайн ургамлын бүрхэц 50.9% байсан байна.

Шимт хөрс хамгаалах арга хэмжээ Өмнөдийн амны шим хөрсний овоолгын 0.1 га талбайд ургамалжуулах ажлыг гүйцэтгэсэн. Тухайн талбайд олон нутгийн унаган ургамал болох ерхөгийн 10 кг үрийг цацаж ургамалжууллаа.



Шимт хөрсний талбайд тарьсан үрийн ургалтын байдал /7-р сар/

2.3 ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР АЖЛЫН ХҮРЭЭНД

Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд энэ жил 10000 ш бургас модны мөчир бэлтгэн ил талбайд 5 дугаар сарын 20-ноос тарьж эхэлсэн. Уурхайн талбайд мөчир бойжуулах ажлыг гүйцэтгэсэн бөгөөд 8 дугаар сард ургалтын өсөлтийг тогтооход хамгийн өндөр нь 150 см, хамгийн намхан нь 30 см ургасан байсан.

Завханмандал сумын төвийн зүүн талд байрлах Ногоон хэрмийн орчим 2 га талбайг хашаалж, мод тарихад бэлтгэсэн. Бойжуулсан суулгацыг мод тарих талбайдаа 2024 оны 10 сарын 18-наас шилжүүлэн суулгаж, худаг гарган, усалгаа, арчилгаа, хамгаалалтын асуудлыг цогцоор нь шийдсэн. Бидний бэлтгэсэн 2 га хашаалсан талбайд нийт 4500 ширхэг суулгац тарьсан.

Шилжүүлэн тариагүй үлдсэн 5500 суулгацыг ирэх хавар дахин талбай бэлтгэн тарихаар төлөвлөж, 2x2 метрийн хэмжээтэй гүн нүх бэлтгэн хадгалсан болно.



Бортогонд тарьж буй байдал



Ургалтын байдал



2 га талбайд шилжүүлэн тарилт

2.4 ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНГИЙН НОГООН БАЙГУУЛАМЖ

2021 онд Завхан аймгийн Улиастай хотын баруун урд хэсэгт байгуулж буй цэцэрлэгт хүрээлэнд 4 га талбайд мод тарьж хүлээлгэн өгснөөс хойш жил бүр нөхөн тарилтыг хийж арчилгаа тордолгоог хариуцан ажиллаж байна. Энэ жил мөн иргэн Г.Гүррагчаатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 4 дугаар сараас 11 сарыг дуустал хугацаанд харуул хамгаалалт арчилгааны ажлыг

гүйцэтгүүлсэн. 2024 оны хаврын тариалалтаар тус талбайд 700 ширхэг хайлаасны 3 настай суулгац тарьж, Аймгийн Байгаль орчин Аялал жуулчлалын газрын мэргэжилтэн Т.Ариунзаяад хүлээлгэн өгсөн.



Хавар 700ш хайлаас мод тарьсан нь



Намар ургасан байдал

3. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

2021 онд хийлгэсэн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үндэслэн дүйцүүлэн хамгаалах талбайн хэмжээг 9.4 га гэж тогтоож өгсөн.

БОННУ-г Мандал багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэх үед иргэдээс тухайн талбайд мод тарих хүсэлтийг гаргаж, санал нэгтэй дэмжиж, 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн багийн иргэдийн нийтийн хурлаар тогтоол гарган албажуулсан байдаг.

Энэхүү шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор тухайн талбайд мод тарих боломж, нөхцөлийг судлуулах зорилгоор ХААИС-ийн багш д-р. Ариунсүрэнгээр судалгааны ажлыг өнгөрсөн жил хийлүүлсэн. Судалгаагаар тухайн талбайд мод тарих нөхцөл муу байгааг ч уулын суваг шуудуу дагуулан нутгийн унаган бутлаг мод болох алтанхарганыг тарих зөвлөмжийг өгсөн.

Иймд энэ онд нутгийн бутлагмод болох алтан харганыг үрээр тарьж бойжуулах ажлыг төлөвлөн гүйцэтгэлээ.

3.1 Суулгац бэлтгэх

Нутгийн унаган ургамал болох алтанхаргана болон хайлаас модыг хүлэмжид үрээр тарилт хийж бэлтгэсэн. Нийт бөгөөд 500 ширхэг алтан харганы 1 настай суулгац, 2500 ширхэг хайлаас модны суулгацыг бойжуулсан. Эдгээр суулгацуудыг хүлэмжид өвөлжүүлж, 2025 оны хавар гадаа талбайд гаргаж, 2026 оны хавраас дүйцүүлэн хамгааллын талбайдаа шилжүүлэн тарилт хийнэ.



Хаврын 3000ш хайлаас болон алтан харганы үрээр тарилт хийж байгаа нь

3.2 ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТАЛБАЙД АМЬТНЫ СУДАЛГАА ХИЙХ

Энэ жилийн хувьд Дүйцүүлэн хамгааллын талбай болох 9,4 га талбайд тарвага нутагшуулж болох талаар судалгааг мэргэжлийн байгууллага болох “Отгон бор хавцал” ТББ-аар хийлгэсэн.

2024 оны 08 болон 10дугаар сарын хооронд нийт 2 удаагийн явалтаар судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Судалгааны бүрэлдэхүүнд Отгон-Бор хавцал ТББ-ын амьтан судлаач А.Хүрэл-Эрдэнэ, Судлаач Н.Баянбат, Гэрээт ажилтан О.Ёндонсамбуу, Уурхайн байгаль орчны мэргэжилтэн Б.Нүрээд нарын бүрэлдэхүүнтэй хэерийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн.

Судалгаанд хамруулах газруудын байршил



МОНГОЛ ТАРВАГА СЭЛГЭН НУТАГШУУЛАХ БОЛОМЖ

Монгол тарвага нь экологийн хувьд тархац нутгийнхаа хөрсний сийрэгжүүлэлт, ургамлан бүрхэвчийн зохицуулалт, үрийн фонд зэргийг бүрдүүлдэг. Идэш тэжээлийн хэлхээнд саарал чоно, шар үнэг, тарважи бүргэд зэрэг амьтдын гол хоол тэжээл нь болдог. Мөн Шар үнэг, Хярс, Мануул, Туулай зэрэг амьтад тарваганы эзэнгүй нүх, ичээг үүр, нуувч болгон ашигладаг байна.



Монгол тарвага нь Зүүн шувуун уулын зүүн бэлд тохиолдсон бөгөөд тоо толгойн хувьд харьцангуй цөөн байгаа нь судалгааны явцад ажиглагдаж байв. Мөн Монгол тарвагыг нутагшуулахад одоогийн тэмдэглэгдээд байгаа газруудад нэмж тавих байдлаар 8-10 бодгаль буюу 8 эм, 2 эр бодгаль нутагшуулахыг санал болгож байна.

Бид тарвага тэмдэглэгдсэн 3 газрын ургамлын бичиглэлийг хийж тухайн газартай ойролцоо /Хуучин нүхтэй/ нутагшуулах боломжтой 4 газрыг сонгон авч ургамлын бичиглэлийг хийж зүйлийн бүрдлээр нь төсөө зүйн анализыг хийсэн. Үүний үр дүнд Тарвага тэмдэглэгдсэн 1, 2, 3 дахь амьдрах орчин, Боломжит амьдрах орчин 1, 3, 5 зэрэг амьдрах орчнууд нь зүйлийн бүрдлийн хувьд хамгийн ойролцоо гарч байгаа нь эдгээр амьдрах орчнуудад тарвагыг нутагшуулахад хамгийн тохиромжтой байна.

Судалгааны талбай орчимд бүртгэгдсэн Хөхтөн амьтдын зүйл

№	Зүйлийн нэр	Англи нэр	Латин нэр
1	Болзлог зурам	Red-cheeked ground squirrel	<i>Spermophilus erythrognus</i>
2	Сибир алагдаага	Siberian jerboa	<i>Allactaga sibirica</i>
3	Хадны барагчин	Mongolian silver vole	<i>Alticola semicanus</i>
4	Шар чичүүл	Midday Gerbil (Midday Jird)	<i>Meriones meridioanus</i>
5	Дагуур огдой	Daurian pika	<i>Ochotona dauurica</i>
6	Бор туулай	Tolai hare	<i>Lepus tolai</i>
7	Дэлдэн зараа	Long-eared hedgehog	<i>Hemiechinus auritus</i>
8	Саарал чоно	Grey wolf	<i>Canis lupus</i>
9	Шар Үнэг	Red fox	<i>Vulpes vulpes</i>
10	Мануул мий	Pallas' cat or Manul	<i>Felis (Otocolobus) manul</i>
11	Хадны суусар	Beech marten	<i>Martes foina</i>
12	Өмхий хүрэн	Steppe polecat	<i>Mustela eversmannii</i>
13	Цагаан зээр	Mongolian gazelle	<i>Procapra gutturosa</i>
14	Монгол тарвага	Siberian or Mongolian marmot	<i>Marmota sibirica</i>

Амьтны судалгааг Шувуун хар уул уурхайн компанийн лицензтэй талбай болох Зүүн шувуун, Баруун шувуун Бүрхээр хар уулаас хойш Нурамтын баруун энгэрээс Харганатын хоолой хүртэл газрыг хамруулан хийж гүйцэтгэсэн учраас дүйцүүлэн хамгаалах талбайг дангаар нь авч судлаагүй байна. /Талбайн хэмжээ маш бага тул амьтны судалгааг том талбайг хамруулан гүйцэтгэдэг/ Иймд орчны хяналт шинжилгээний хэсэгт байгаа амьтны судалгаанд энэхүү дүйцүүлэн хамгааллын талбай багтсан болно. Иймд нэмэлт мэдээллийг тус хэсгээс харна уу.

4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Энэ онд нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын талаар төлөвлөгөөнд тусгагдаагүй болно.

5. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Энэ онд уурхайн геологи хайгуулын ажлын үед болон ашигт малтмалын ашиглалтын явцад ямар нэгэн түүх соёлын өвд хамаарах эд өлгийн зүйл, археологи болон палеонтологийн олдвор илрээгүй болно.

6. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 оны 7 дугаар сараас Боловсруулах үйлдвэрийн өргөтгөлийн уусган баяжуулах хэсгийг бүрэн ашиглалтад оруулж зөвшөөрөл авсны дагуу 14 нэр төрлийн химийн бодис ашиглахаар төлөвлөж байсан. Гэвч орон нутгийн иргэдийн зүгээс санал гомдол гарсан учраас химийн бодис ашиглах хугацааг хойшлуулсан. Хэдийгээр нийт 16 ажил төлөвлөсөн боловч дээрх нөхцөл байдлаас үүдэн зарим ажлууд хийгдээгүй болно.

Химийн бодисын тээвэрлэлтийн үед авах арга хэмжээ		
1	Химийн бодисыг тээвэрлэхийн өмнө замын маршрутыг тогтоох	2024 оны 7 дугаар сараас эхлэн химийн бодис ашиглахаар төлөвлөсөн байсан тул 3 дугаар сард химийн бодисын тээвэрлэлтийн ажлыг эхлүүлсэн. Тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж болох Брайт Транс ХХК-тай гэрээ байгуулж, холбогдох журмын дагуу тээвэрлэлтийн ажлыг гүйцэтгүүлсэн. Тээвэрлэлт эхлэхийн өмнө замын маршрутыг тогтоон зурагжуулж тээвэрлэлтийн үеийн аюулгүй ажиллагааны төлөвлөгөөнд хавсарган Онцгой байдлын Ерөнхий газраар батлуулан тээвэрлэлтийг гүйцэтгэсэн. Маршрутын зургийг хавсаргав.
2	Химийн бодисын тээвэрлэлтийн үеийн аюулгүй ажиллагааны төлөвлөгөө боловсруулах	Тээвэрлэлт эхлэхийн өмнө Тээвэрлэлтийн үеийн ослын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулан Онцгой байдлын ерөнхий газраар батлуулсан. <i>Төлөвлөгөөний нүүрийг хавсаргав.</i>
3	Химийн бодисыг тээвэрлэх үедээ тээврийн хэрэгсэлд тэмдэг тэмдэглэгээг журмын дагуу байрлуулах	Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журамд заасны дагуу тээврийн хэрэгслүүдэд шаардлагатай тэмдэг тэмдэглэгээг байрлуулж тээвэрлэсэн. <i>Зургийг хавсаргав.</i>
4	Тээвэрлэлт эхлэхийн өмнө нийт жолооч нарт химийн бодисын сургалтад хамруулах	Тээвэрлэлт эхлэхийн өмнө тээврийн хэрэгслийн жолооч нарыг Химийн бодисын аюулгүй ажиллагааны сургалтад хамруулсан. <i>Сургалтад хамрагдсан ажилчдын бүртгэлийг хавсаргав.</i>
Химийн бодисын хадгалалтын үед авах арга хэмжээ		
5	Химийн бодисыг хадгалах ААЗ боловсруулах	Нийт 14 бодис тус бүрт ААЗ-г боловсруулсан. <i>Зураг хавсаргав.</i>
6	Химийн бодис нэг бүрийн ХАЛМ-ийг агуулах бүрд байршуулах	Химийн бодис нэг бүрийн ХАЛМ-г байршуулсан байдлын зургийг хавсаргав.
7	Химийн бодисыг зарцуулалтад тогтмол бүртгэл хөтлөх	Бүртгэлийн дэвтрийг бэлтгэсэн боловч одоогоор ашиглаагүй байна.
8	Химийн бодисын сав баглаа боодлын хаягдалд бүртгэл хөтлөх	Бүртгэлийн дэвтрийг бэлтгэсэн боловч одоогоор ашиглаагүй байна.
9	Химийн бодисыг сав баглаа боодлыг саармагжуулан хадгалах,	Мэргэжлийн эрх бүхий байгууллагууд болох Цэцүүх ХХК, Элемент ХХК-тай гэрээ байгуулан баталгаажуулсан. Одоогоор нийлүүлээгүй байна. Гэрээний нүүрийг хавсаргав.

	дахин боловсруулах эрх бүхий мэргэжлийн байгууллагад өгөх	
Химийн бодисын ашиглалтын үед авах арга хэмжээ		
10	Химийн бодисыг ашиглах ААЗ боловсруулах	Боловсруулах үйлдвэрийн хэмжээнд химийн бодис ашиглахтай холбоотой нийт 63 ААЗ боловсруулсан. <i>Зургийг хавсаргав.</i>
11	Химийн бодисыг ашиглалтын үеийн аюулгүй ажиллагааны сургалт хийх	Химийн бодис ашиглах аюулгүй ажиллагааны сургалтыг дотооддоо 4 удаа давхардсан тоогоор нийт 61 ажилтанд орсон. Мэргэжлийн 2 байгууллагаас үнэмлэх олгох сургалтыг 2 удаа 31 ажилтныг хамруулсан.
12	Баяжуулах үйлдвэрийн шугам хоолойд үзлэг шалгалт хийж, тогтмолжуулах	Армос ХХК-тай гэрээ байгуулан даралтат сав шугам хоолойг баталгаажуулах ажлыг 10 дугаар сараас эхлэн гүйцэтгүүлж байна. <i>Гэрээг хавсаргав.</i>
13	Химийн бодисын сав баглаа боодлыг саармагжуулан хадгалах, дахин боловсруулах эрх бүхий мэргэжлийн байгууллагад өгөх	Мэргэжлийн эрх бүхий байгууллагууд болох Цэцүүх ХХК, Элемент ХХК -тай гэрээ байгуулан баталгаажуулсан. Одоогоор нийлүүлээгүй байна. <i>Гэрээний нүүрийг хавсаргав.</i>
14	Химийн бодисын зарцуулалтын улирлын тайланг Аймгийн БОАЖГ-т хүргүүлэх	
15	Химийн бодисын зарцуулалтын хагас жил, жилийн эцсийн тайланг Завханмандал сумын ЗДТГ-т хүргүүлэх	Химийн бодис ашиглаагүй боловч “Х” буюу ашиглаагүй тайланг улирал бүр Аймгийн Цагдаагийн газар, Байгаль орчин аялал жуулчлалын газар, Онцгой байдлын газар, Тагнуулын хэлтэст ту тус д хүргүүлдэг.
16	Химийн бодисын зарцуулалтын жилийн тайланг БОАЖЯ-нд хүргүүлэх	

6.1 Химийн бодисын тээвэрлэлтийн үеийн батлагдсан маршрут



Нэгэн завхарсан маршрутын дагуу
 олонтоор биеэвэрлэх үйл
 ажиллагаанд оролцоно.

6.2 Тээвэрлэлтийн үеийн ослын үед ажиллах төлөвлөгөөний батлагдсан нүүр

BRIGHT TRANS
 БАТЛАВ.
 "БРАЙТ ТРАНС" ХХК-ийн Гүйцэтгэх
 Захирал *[Signature]* Г.БАТМӨНХ
 2024/02/14

ОБЕГ-ЫН АЖИЛЛАГА АНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА, -2
 ХУРАНДАА *[Signature]* Б.БАЯНМӨНХ
 2024/ /

ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН НУТАГ ДАХЬ ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН НИСЭХ
 БУУДЛААС ЗАВХАН АЙМГИЙН ЗАВХАНМАНДАЛ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ "ШУВУУН
 ХАР УУЛ" ХХК-НИЙ УУРХАЙН ТАЛБАЙД 16.0 ТОНН НАТРИЙН ЦИАНИДЫГ АВТО ЗАМААР
 ТЭЭВЭРЛЭХ БА АЧИЖ БУУЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦАД ГАРЧ БОЛЗОШГУЙ ОСЛЫН
 ҮЕД АЖИЛЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 ОНЫ 02 ДУГААР САРЫН 22-НЫ ӨДРӨӨС 03 ДУГААР САРЫН 14-НЫ ӨДРИЙГ ХҮРТЭЛ

УЛААНБААТАР ХОТ

3 хувь үйлдэл

2024 он

6.3 Тээвэрлэлтийн үед тэмдэг, тэмдэглэгээ байрлуулсан тээврийн хэрэгсэл ашигласан.



6.5 Химийн бодисын хадгалалтын үеийн ААЗ

ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХАД НАТРИЙН ЦИАНИДАЙ АЖИЛЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР	ХИМИЙН БОДИСЫН АГУУЛАХАД НАТРИЙН ЦИАНИДАЙ АЖИЛЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР			БАЯЖУУЛАХ ҮЙЦДВЭР
	Овог нэр	Төрөл үзэг	Огноо	
Батлагсан Гүйцэтгэх захирал Г.Золбаяр			2023	Хянах хугацаа 24 сар
Хянасан ХАБ-ын эхлэл: Ө.Багчиныг				Нэмэлт өргөлдөгч 2023.05.27
Боловсруулсан Хянагч: С.Одоонзвыг				Хугацааг тоо

ЗОРИЛГО:

Энэхүү ААЗ нь химийн бодисын агуулахад байгаа натрийн цианидай эрхэн аюулдгүйгээр ажиллах, тухайн эхлэл ажиллаж буй оператор болон ажилтан хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж, таамаглаагүй аюул осол тохиолдлоос урьдчилан сэргийлэх зорилготой бууруулах зорилготой.

ХАМРАХ ХҮРЭЭ:

Энэхүү ААЗ-г Баяжуулах үйлдвэрийн химийн бодисын агуулахад ажиллаж байгаа болон натрийн цианидай харьяа ажиллах нийт ажилтан дагаж мөрдөнө.

ЭНЭХҮУ ДААЛГАВАРТ ДООРХ ХУВИЙН ХАМГААЛАХ ХЭРГЭСЭЛ ШААРДЛАГАТАЙ:



АЖИЛ ЭХЛЭХИЙН ӨМНӨ ДООРХ ШААРДЛАГУУДЫГ ХАМГААСАН БАЙХ ШААРДЛАГАТАЙ:

- Ажилтан ажлын байрны ангын шатны зааварчилгаа авсан байна
- Химийн хорт болон аюултай бодисын ашиглах, хадгалах, тээвэрлэх журамтай танилцсан байна.
- Химийн хорт болон аюултай бодисын ослын үед авах журмыг унших танилцсан байна.

- Агааржуулалтын систем, вентилятор хэвийн ажиллаж байгаа эсэхийг шалгана.
- Агуулахын шалд будрах, тээглэх, хальтрах биет байгаа эсэхийг сайн шалгана.
- Тухайн химийн бодисын сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал, битүүхэнтэй эвлэлдсэн эсэхийг шалгана.
- Химийн бодисын савалтан дээрх шошгыг шалгана.
- Өргөгч техникийг агуулахын үүдэнд байрлуулж химийн бодисыг зөөхөд бэлтгэнэ.
- Операторууд 50кг савалтаат бодисыг болгоомжтой өргөн өргөгч техник дээр унахааргүй байрлуулж тавина.
- Өргөгч техникийг агуулахын үүднээс холдуулж, хаалгыг хамаад бэлтгэнэ.
- Агуулахын хаалгыг хааж хамгаалалтын ажилтан ландана.
- Бодис өрсөн өргөгч техникийг үйлдвэрт хурч хүртэл оператор болон ХАБ-ын ажилтан хяналт тавина.
- Тээвэрлэлтийн үед сав баглаа боодол задарсан болон гэмтсэн эсэхийг шалгана.
- Үг бодисыг хүлээн авсан болон хүлээлгэн өрсөн ажилтнууд бүртгэлийн хуудсыг бөглөж, гарам үзэг зурна.
- Ашигласан хувиас болон багаж хэрэгсэлийг зориулалтын байранд нь буцааж тавина.
- Оператор ажил дууссан тухай ээлжийн мастерг

АГУУЛАХАД БОДИСТОЙ АЖИЛЛАХАД БАРИМТЛАХ САНАМЖ:

- **Син цортой химийн бодистой харьяа байгаа ажилтан нь ажлаа гавалсаа тусгай зориулалтын хувцас хэрэгсэлийг өмсөж байх шаардлагатай.**
- Оператор энэхүү ААЗ-г дагаж ажилла хийж гүйцэтгэнэ.
- Сав баглаа боодол, битүүхэж алдагдсан эвэр хэвийн бүх байдлыг хянагчид даруй мэдэгдэнэ.

АГУУЛАХАД БОДИСТОЙ АЖИЛЛАХАД ХОРИГЛОХ ЗҮЙЛС:

- Зөвшөөрөлд тусгагдсан хэмжээгээ илүү болон өөр химийн бодис агуулахаас гаргахыг хориглоно.
- Агуулахад болон ойр орчинд ил гал гаргах, тэмцэ татахыг хориглоно.
- Агуулахад зөвшөөрөлгүй этгэдгийг нэвтрүүлэхийг хориглоно.
- Ажилтан хорт бодис хэрэглэхийг хориглоно.

6.6 Химийн бодис нэг бүрийн ХАЛМ-ийг агуулах бүрд байршуулсан



6.9 Химийн бодисыг сав баглаа боодлыг саармагжуулан хадгалах, дахин боловсруулах эрх бүхий мэргэжлийн байгууллагатай хийсэн гэрээ

БАТЛАВ: "ЦИНУУХ ГРЭВД" ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Н.ИВЭНДЭВ

БАТЛАВ: "ЦИВУУН ХАР УУЛ" ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.ЭЛЭДЛЭР

ХИМИЙН БОДИС ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ
№ Х-23/0.

2023 оны 11 сарын 27-ний өдөр

Энэхүү гэрээг нэг талаас Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайвны өргөн замын 64/2 туслах байрны 2066521 регистрийн дугаартай "Цибууш Грөвд" ХХК (өмчлөн "Хуваалдагч") тус түүний төлөөлөгч Санхүү, Хуульчлан харуулах хэлтэс Б.Давалзан, нөгөө талаас Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо 13-р хороогоор Энхтайвны өргөн замын "Тэгш" байрны 2320897 регистрийн дугаартай "Цибууш хар уул" ХХК (өмчлөн "Хуваалдагч") тус түүний төлөөлөгч менежер ажил тусламттай Б.Буриа нар (байнгүй тус өргөгч) нь "Тэг", хамттай нь "Тэгэр" тус Монгол Улсын Иргэний хуулийн 242-261-р зүйцүүдийг үндэслэн, дараах нөхцөлөөр харацтан тохиромжон энэхүү гэрээг байгуулна.

НЭГ, НИЙЦЛЭГ ҮЙЦЭСЭЛ

1.1 Энэхүү гэрээгээр Хуваалдагч нь Хуваалдсан бодисын ажилтан дагуу МУ-ын болон олон улсын чандарын шаардлагыг бүрэн зориулсан гэрээний шаардлагад тусгасан Химийн урвалж бодисыг (бодисыг "Бодис" гэж) Хуваалдсан ажилтан тохиромжон хуваахад нийцүүлж, Хуваалдсан ажилтан нь хуваалдагч талд өргөмжлөн тохиромжон үнийг тооцож, хуваалдсан ажилтан бодисыг хуваалдсан талд хүлээн авчгаж ажиллагааг хариуцаж төлөхөд зориулсан халах эрх, хуваах үүрэг, хариуцаж ажиллагааг зохицуулна.

1.2 Энэхүү гэрээгээр хуваа хариуцаж ажиллагааг бүрэн хариуцаж Монгол Улсын иргэний хууль, түүхч нийцүүлэн гарсан бусад хууль тогтоомжоор зохицуулна.

1.3 Гэрээ нь 3 сарын туршийд бодисын нэг нь гэрээний агуулгыг хэсэг байна.

1.3.1 Хавартай № 1 Үүний өмнө "Хуваалдсан Химийн бодисын төмөр, нэр, төрөл, тус хэмжээ, тус бүрэн үнэ, хариуцаж ажиллагааг зохицуулна."

1.3.2 Хавартай №2 Хуваалдсан бодисын нэг нь гэрээний агуулгыг хэсэг байна.

1.3.3 Хавартай №3 Химийн бодисыг хуваалдсан ажилтан.

1.4 Хуваалдсан бодис бүрэн гэрээний 1.3.1, 1.3.2, 1.3.3-д заасан хавартаа тус тус үйлдэн, хавартай тус бүр энэхүү гэрээний агуулгыг тэмдэг гэрээнд хариуцана.

ХОЁР, ГЭРЭЭНИЙ ҮЙЦЭХ ХУГАЦАА

2.1 Гэрээний үйлдэх хугацаа 2023 оны 11 дугаар сарын 27-ны өдөрөөс 2024 оны 11 дугаар сарын 27-ны өдөр хүртэл байна.

2.2 Гэрээний үйлдэх хугацааг хоёр тал бичигээр тохиромжлоноор сунгаж болно.

2.3 Гэрээний үйлдэх хугацааг дараах тохиолдолд зогсоож болно:

- Талууд нөхцөлөөрөө
- Монгол улсын эрх бүхий байгууллагын шаардлагаар

Хуульчлан байгуулагч: Хуваагч: ИВ

БАТЛАВ: "ЦИВУУН ХАР УУЛ" ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ЭЛЭДЛЭР

БАТЛАВ: "ЦИВУУН ХАР УУЛ" ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.ЭЛЭДЛЭР

ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ХАГАДАГЧ ӨРГӨГЧ, УСТГАА АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ
№ ХБ-24/04

2024 оны 4-р сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГ, НИЙЦЛЭГ ҮЙЦЭСЭЛ

1. Нэг талаас "Цибууш" ХХК (өмчлөн "Хуваалдагч") тус түүний төлөөлөгч Санхүү, Хуульчлан харуулах хэлтэс Б.Давалзан, нөгөө талаас Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо 13-р хороогоор Энхтайвны өргөн замын "Тэгш" байрны 2320897 регистрийн дугаартай "Цибууш хар уул" ХХК (өмчлөн "Хуваалдагч") тус түүний төлөөлөгч менежер ажил тусламттай Б.Буриа нар (байнгүй тус өргөгч) нь "Тэг", хамттай нь "Тэгэр" тус Монгол Улсын Иргэний хуулийн 242-261-р зүйцүүдийг үндэслэн, дараах нөхцөлөөр харацтан тохиромжон энэхүү гэрээг байгуулна.

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал нь зориулалтын нөхцөл зүүхэд химийн бодисын аюултай хорт бодисын гэрээнд заасан хуваалдсан бодисыг тохиромжон, устгагчид оршино.

1.2. Захиалагч тал нь гэрээнд заасан хуваалдсан бодисыг гүйцэтгэгч талд хүлээн авчгаж ажиллагааг зохицуулна.

ХОЁР, ДАХИНАЛГА ТАЛЫН ЭРХ ҮҮРЭГ

2.1. Захиалагч дараах эрхтэй.

2.1.1 Гүйцэтгэгч талыг гэрээгээр хуваалдсан үүрэг бодисыг ажилтан шаардаж эрхтэй.

2.1.2 Химийн хорт болон аюултай бодисыг ажилтан шаардаж ажиллагааг зохицуулна.

2.1.3 Химийн хорт болон аюултай бодисыг ажилтан шаардаж ажиллагааг зохицуулна.

2.2. Захиалагч дараах үүрэгтэй.

2.2.1 Ажилтан хорт бодисыг "Хорт бодисын хуваах үүрэг" 23 дугаар зүйцүүн 22.2 дүгээр хэсэгт заасан ажилтан хорт бодисыг ажилтан шаардаж ажиллагааг зохицуулна.

2.2.2 Үүрэг ажилтан шаардаж ажиллагааг зохицуулна.

2.2.3 Хорт бодисын хуваах үүрэгтэй үйлдвэрийн 23 дугаар зүйцүүн 23.1 дүгээр хэсэгт заасан ажилтан шаардаж ажиллагааг зохицуулна.

2.2.4 Ажилтан хорт бодисыг ажилтан шаардаж ажиллагааг зохицуулна.

2.2.5 Хуваалдсан хорт бодисыг ажилтан шаардаж ажиллагааг зохицуулна.

2.2.6 Ажилтан хорт бодисыг ажилтан шаардаж ажиллагааг зохицуулна.

2.2.7 Захиалагчийн бүрэлдэх үйл ажиллагааны үеийн гүйцэтгэгчийн ажилтан бүрэлдэх үйл ажиллагааны үеийн гэрээний ажилтан шаардаж ажиллагааг зохицуулна.

6.10 Химийн бодисыг ашиглах үеийн ААЗ

АЗОТЫН ХҮЧИЛТЭЙ АЖИЛЛАХ ҮЕИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА				
Овог нэр	Гарам үсэг	Огноо	БУ-УХ-005	
Баталсан:				
Гүйцэтгэх захирал: Г.Золбаяр		2023.08.20	Хянах хугацаа	24 сар
Хянасан:			Нэмэлт өөрчлөлт	
ХАБЭА-ий ахлах: Ө.Батчимэг			Хуудасны тоо	
Боловсруулсан:				
Бажуудалтын инженер:				

ЗОРИЛГО:

Энэхүү ААЗ нь азотын хүчилтэй харьцан ажиллах үйлдвэрийн операторууд болон химич, лабораторин туслах зэрэг ажилтан келемэрийн аюулгүй байдлыг хамгаах, таамаглаагүй аюул оооо тохиолдоос урьдчилан сэргийлж, аюул осолгүй ажиллах, эрсдэлийг бууруулах зорилготой.

ХАМРАХ ХҮРЭЭ:

Энэхүү ААЗ-г азотын хүчилтэй харьцан ажиллах байгаа ажилтнууд болон эзэлхэйн мастер дагаж мөрдөнө.

ЭНЭХҮҮ ДААЛГАВАРТ ДООРХИ ХУВИЙН ХАМГААЛАХ ХЭРГЭСЭЛ ШААРДЛАТАЙ:



ДУУЛГА НУДНИЙ ШИЛ ЧИХЭВЧ ХОШУУВЧ ГУТАЛ БЭЭЛИЙ ХУВСАС

АЖИЛ ЭХЛЭХИЙН ӨМНӨХ ШААРДЛАГА:

- Химийн бодисын савалгаан дээрх шонгыг шалгана.
- Өргөгч техникийг агуулахын үүдэнд байрлуулж химийн бодисыг зөөхөд бэлтгэнэ.
- Оператор 25л-ийн савалгаатай азотын хүчлийг болгоомжтой өргөн өргөгч техник дээр унахааргүй байрлуулж тавина.
- Агуулахын хаалгыг хааж хамгаалалтын ажилтан лалдана.
- Өргөгч техникийг бодисыг үйлдвэрт хүрэх хүртэл оператор болон ХАБ-ын ажилтан хяналт тавина.
- Тээвэрлэлтийн үед сав баглаа боодол задарсан болон гэмтсэн эсэхийг шалгана.
- Уг бодисыг хүлээн авсан болон хүлээлгэн өгсөн ажилтнууд бүртгэлийн хуудсыг бөглөж, гарам үсэг зурна.
- Химийн бодисыг нэг нэгээр алтны өрөө рүү зөөнө.
- Алтны өрөөний оператор савтай азотын хүчлийн тагьг онгойлгож найруулах танк руу хийнэ.
- Сударсан сав, баглаа боодлыг аюултай ког хаягдалын тур хаягдах нэгт байрлуулна.

АЗОТЫН ХҮЧИЛТЭЙ АЖИЛЛАХАД БАРИМТЛАХ САНАМЖ:

- Оператор энэхүү ААЗ-г дагаж ахлаа хийж гүйцэтгэнэ.
- Сав баглаа боодол, битүүнж, алаагдсан зэрэг хэвийн бус байдал хэмчлэх мэдэгдэнэ.
- Азотын хүчил асарсан тохиолдолд усаар угааж ивэрлэнэ.

АЗОТЫН ХҮЧИЛТЭЙ АЖИЛЛАХАД ХОРНГЛОХ ЗҮЙЛС:

- Зөвшөөрд тусгагдсан хэмжээгээс илүү болон өөр химийн бодис агуулахаас гаргах.
- Ил гал гаргах, чүдэн зурах, талхи татах.
- Нэг бүрийн хамгаалах хэрэгслийг ажил дуусахаас өмнө тайлахыг хориглоно.

АЛХАМУУДАД ХАМААРАХ БОЛЗОШУЙ АЮУЛЫГ ЗАЙЛУУЛАХ:

- Алхаарал болгоомжтой бай!

6.12 Армос ХХК-тай байгуулсан гэрээ



АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2024 оны 10-р сарын 16-ны өдөр № Улаанбаатар хот

Нэг талаас: 5320607 регистрийн дугаар бүхий "Шувуун Хар Уул" ХХК /цаашид "Захиалагч тал" гэх/ түүнийг төлөөлж хуульч Г.Оюундарь. Нөгөө талаас: 5247764 регистрийн дугаар бүхий АРМОС ХХК /цаашид "Гүйцэтгэгч тал" гэх/ түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Б.Жигсэлмаа нар Монгол улсын Иргэний хуулийн холбогдох зүйл заалтыг үндэслэн доорх нөхцөлүүдийг харилцан тохиролцсоны үндсэн дээр Захиалагч тал үл эвдэх сорилын ажлыг Гүйцэтгэгч талаар хийж гүйцэтгэхээр энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал нь Захиалагч талын ажлын даалгаварт заасан ажлын үл эвдэх сорил баталгаажуулалтын ажлыг гүйцэтгэж, сорил шалгалт хийх үеийн байдлаар үр дүн, тайлан дүгнэлт гаргах ажлыг чанарын болон мэргэжлийн өндөр түвшинд хийж, даралтат сав шугам хоолойтой харьцах аюулгүй ажиллагааны сургалтыг өгөх, Захиалагч тал нь гэрээнд заасан төлбөрийг төлөх болон эдгээртэй холбоотой бусад харилцааг зохицуулахад оршино.
- Ажлын даалгаварт заасан даралтат саванд үл эвдэх сорил шалгалтыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, журам, стандарт, норм дүрэм болон гэрээнд заагдсан нөхцөлүүдийн дагуу хийж байхыг зорилго болгоно.

6.14 Төрийн байгууллагууд руу явуулсан химийн бодис ашиглалтын Х тайлан



ЗАВХАН АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАРТ

2024.09.10 № 152 танай -ны №

Тайлан хүргүүлэх тухай

Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, нил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах аж ахуйн үйл ажиллагааны 0002557 дугаартай дугаартай тусгай зөвшөөрлийн дагуу Завхан аймгийн Захиргааны газрын сумын нутагт байрлах MV-021001 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн химийн бодисын үлдэгдлийн тайланг хавсралтаар хүргүүлэн.

Бажуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглаж эхлээгүй, үйлдвэр бүрэн хүчин чадлаар ажиллаагүй байгаа болно.

Хавсралт 1 хуудастай.

2024 оны 10-р сарын 10-ны өдөр /10/ тоот албан ёсоор хавсралт №1

MV-021001 тоот тусгай зөвшөөрөл бүхий талбайн 8-р сарын химийн бодисын тайлан

№	Химийн бодисын нэр	Олон улсын нэршил	CAS дугаар	Химийн томъёо	Хэмжих нэгж	Эзний үлдэгдэл	Орлого	Зарлага	Үлдэгдэл
1	Натрийн цианид	Sodium cyanide	143-33-9	NaCN	кг	0	16,000		16,000
2	Натрийн нитрат	Sodium nitrate	1310-73-2	NaNO3	кг	0	3,000		3,000
3	Шоош	Calcium oxide	1305-78-8	CaO	тн	0	40		40
4	Азотын хүчил	Nitric acid	7697-37-2	HNO3	кг	0	3,000		2,000
5	Давсны хүчил	Hydrochloric acid	7647-01-0	HCl	кг	0	18,000		17,000
6	Флюксант	Fluoroboric acid	9005-05-08	C2H3-NH2	кг	0	1,000		1,000
7	Техникийн сод	Sodium carbonate	497-19-8	Na2CO3	кг	0	3,000		3,000
8	Кальцийн гипохлорит	Calcium hypochlorite	7778-54-3	CaClO2	кг	0	6,000		6,000
9	Бор	Sodium borate	1303-96-4	Na2B4O7*10H2O	кг	0	1,000		1,000
10	Хүрвийн хүчил	Sulfuric acid	7664-93-9	H2SO4	кг	0	115		101.5
11	Эсийн сульфат	Copper sulfate	7758-98-7	CuSO4	кг	0	100		1,000
12	Идэвхижүүлсэн нүүрс	Activated Carbon	7440-44-0	C	кг	0	10,000		10,000
